



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/Н

Сүхбаатар

**2015 оныг “Иргэн-таны төлөө” жил
болгон зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а” дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2015 оныг төрийн үйлчилгээний чанар хүртээмж, сахилга хариуцлага, төсөв санхүүгийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх үүднээс “Иргэн-таны төлөө” жил болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд иргэдийн итгэл хүндлэлийг хүлээн, ажил албан үүргээ хариуцлагатай, үр өгөөжтэй хэрэгжүүлэх үүднээс сум орон нутаг, байгууллагын хэмжээнд ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнахыг сумдын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Зарласан жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд бүтээлч санаачлага, бодитой үр дүн гаргаж ажиллахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ

